



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЦӨМИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA
NUCLEAR RESEARCH CENTER

201 он сар өдөр No.

Улаанбаатар хот
210646, ш/х: 46А/305
Утас/факс: 456348

ЗАХИРЛЫН ТУШААЛ

Нэрэмжит тэтгэлэг бий болгох тухай

Цөмийн судалгааны төвийн Захиргааны зөвлөлийн 2010.10.28-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. Цөмийн судалгааны төвийг үүсгэн байгуулсан монгол улсын физик-математикийн ухааны анхны эрдэмтэдийн алдрыг мөнхжүүлэх; цөмийн физик, технологийн мэргэжлээр суралцаж буй залуучуудын билиг авъяас, ур чадвар, идэвх чармайлтыг дэмжих, уг салбарын хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор академич Намсрайн Содномын нэрэмжит тэтгэлэг бий болгосугай.
2. “Академич Н.Содномын нэрэмжит тэтгэлэг олгох журам”, “Профессор Д.Чүлтэмийн нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ыг тус тус 1 ба 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Нэрэмжит тэтгэлэгт олгох мөнгийг Бизнес төвийн орлогоос зарцуулсугай.
4. Нэрэмжит тэтгэлэгийн тухай оюутан суралцагчдад сурталчлах, тэтгэлэг авахын төлөө идэвх чармайлт өрнүүлэх, зохих ёсоор шалгаруулалт явуулж, нэр дэвшүүлж байхыг Цөмийн физикийн тэнхмийн эрхлэгч /Н.Норов/-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

ПРОФ. С.ДАВАА

Профессор Д.Чүлтэмийн нэрэмжит тэтгэлэг олгох журам

Нэг. Зорилго

1. Профессор Д.Чүлтэмийн нэрэмжит тэтгэлэг (цаашид нэрэмжит тэтгэлэг гэнэ) олгох нь дараах үндсэн хоёр зорилготой. Үүнд:
 - Тус Цөмийн судалгааны төвийг үүсгэн байгуулагчдын нэг, монгол улсын цөмийн физикийн шинжлэх ухааны анхны доктор, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, профессор Даржаагийн Чүлтэмийн алдрыг мөнхжүүлэх;
 - Цөмийн физик, технологийн мэргэжлээр суралцаж буй оюутнуудын билиг авъяас, ур чадвар, идэвх чармайлтыг дэмжих, амжилттай суралцахын төлөө тэмүүлэлийг хөгжөөх.

Хоёр. Нэрэмжит тэтгэлэг олгох нөхцөл

Дараахи нөхцлийг хангасан оюутанд нэрэмжит тэтгэлэг олгоно. Үүнд:

2. Цөмийн физик, цөмийн технологи, цөмийн эрчим хүчний мэргэжлээр суралцаж буй оюутан байх бөгөөд сүүлийн 4 улирлын голч дүн В-ээс доошгүй байх (Сургалтын албанаас гаргасан дүнгийн тодорхойлолтыг үндэслэнэ);
3. Эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж хэлэлцүүлсэн, багаж төхөөрөмж зохион бүтээсэн;
4. Эрдэм шинжилгээний ажилд дур сонирхолтой, авъяас чадвартай оюутан болохыг мэргэжлийн тэнхим, оюутны хамт олон батлан тодорхойлсон байх.

Гурав. Нэрэмжит тэтгэлэг олголт

5. Нэрэмжит тэтгэлэг олгох оюутны нэрийг тэнхмийн хурлаас дэвшүүлнэ.
6. Нэрэмжит тэтгэлэг олгох асуудлыг Төвийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, захирлын тушаалаар баталгаажуулан гэрчилгээг олгоно.
7. Нэрэмжит тэтгэлэгийг хичээлийн жилд нэг оюутанд нэг удаа олгох ба эрдэм шинжилгээний ажилдаа тогтвортой, онцгой амжилт гаргасан оюутанд үргэлжлүүлэн олгож болох бөгөөд уг асуудлыг нэрэмжит тэтгэлэгийг шинээр олгохтой нэгэн адилаар шийдвэрлэнэ.
8. Нэрэмжит тэтгэлэгийн хэмжээ 200,000 төгрөг байх ба мөнгөний ханш, төвийн санхүүгийн байдлыг харгалзан цаашид өөрчлөн тогтоож болно.

*** *** ***

Академич Н.Содномын нэрэмжит тэтгэлэг олгох журам

Нэг. Зорилго

1. Академич Намсрайн Содномын нэрэмжит тэтгэлэг (цаашид нэрэмжит тэтгэлэг гэнэ) олгох нь дараах үндсэн хоёр зорилготой. Үүнд:
 - Тус Цөмийн судалгааны төвийг үүсгэн байгуулагчдын нэг, монгол улсын физик-математикийн ухааны анхны эрдэмтэн, гавьяат багш, академич, профессор Намсрайн Содномын алдрыг мөнхжүүлэх;
 - ЦСТ-ийн багш, ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлж ахисан түвшний сургалтад хамруулах, тогтвор суурьшилтай ажиллах сонирхолыг дээшлүүлэх, төвийн хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Нэг. Нэрэмжит тэтгэлэг олгох нөхцөл

Дараахи нөхцлийг хангасан докторантад нэрэмжит тэтгэлэг олгоно. Үүнд:

2. ЦСТ-д 3-аас доошгүй жил багш, эрдэм шинжилгээний ажилтнаар ажилласан докторант байх,
3. МУИС-ийн докторын сургалтад элсээд 2-оос доошгүй жилдээ суралцаж байгаа бөгөөд өмнөх улирлын сургалтын төлбөрийг төлсөн байх,
4. Сургалтын төлөвлөгөөг биелүүлж зохих ёсоор аттестатчилагдсан, сургалтын 24-өөс доошгүй багц цагийг тооцуулсан байх,
5. Бүтээл нь хэвлэн нийтлэгдсэн буюу үйлдвэрлэл, практикт шилжсэн зохиогчийн гэрчилгээ, лицензи авсан, ялангуяа диссертация хамгаалахад бэлэн болгосон бол эн түрүүнд сайшаагдана.
6. Нэр дэвшигчийг удирдагч, тэнхмийн хамт олон батлан тодорхойлсон байх ба тодорхойлолтонд түүний сургалтын төлөвлгөөний биелэлт, эрдэм шинжилгээний ажлын үр дүн, цаашид тогтвор суурьшилтай ажиллах итгэл найдвартай тухай үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Хоёр. Нэрэмжит тэтгэлэг олголт

7. Нэрэмжит тэтгэлэг олгох докторантыг төвийн хамт олны хурлаас ил тод хэлэлцэж дэвшүүлэн, тэмдэглэл хөтөлсөн байна.
9. Нэрэмжит тэтгэлэг олгох асуудлыг Төвийн Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, захирлын тушаалаар баталгаажуулан гэрчилгээг олгоно.
- 8.
9. Нэрэмжит тэтгэлэгийн хэмжээ 500,000 төгрөг байх ба мөнгөний ханш, төвийн санхүүгийн байдлыг харгалзан цаашид өөрчлөн тогтоож болно.